



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

80.	Эрүүгийн байцаан шийтгэх хуульд өөрчлөлт оруулах тухай	138
81.	Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай	138
82.	Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай	139
83.	Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай	139

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

84.	Газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх хөтөлбөрийн тухай	Дугаар 16	140
85.	Монгол судлалыг хөгжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	Дугаар 17	141
86.	Төрийн аудитын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл буцаах тухай	Дугаар 20	142
87.	Үндсэн хуулийн цэцийн 2014 оны 01 дүгээр дүгнэлтийн тухай	Дугаар 21	142
88.	Хуулийн төсөл буцаах тухай	Дугаар 23	143
89.	Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 25	144
90.	Нууц Протоколыг ил болгох тухай	Дугаар 26	144



91.	Монгол Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Дугаар 27	145
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ			
92.	Журам батлах тухай	Дугаар 374	145
93.	Төлөвлөгөө батлах тухай	Дугаар 389	164
МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ			
2014 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр		Улаанбаатар хот	
ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ			
<p>1 дүгээр зүйл.Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 342 дугаар зүйлийн 342.1 дэх хэсгийн “хохилогчийн өмгөөлөгч” гэснийг “хохилогч болон тэдгээрийн өмгөөлөгч” гэж өөрчилсүгэй.</p> <p>2 дугаар зүйл.Энэ хуулийг 2014 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.</p>			
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА		З.ЭНХБОЛД	
МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ			
2014 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр		Улаанбаатар хот	
ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ			
<p>1 дүгээр зүйл.“ДЦС-4” ТӨХК-ийн суурилагдсан хүчин чадлыг Т-120/130-130-8МО турбинаар өргөтгөх барилга угсралтын ажлыг гүйцэтгэхэд шаардагдах тоног төхөөрөмж, сэлбэг материал, багаж хэрэгслийг импортлоход гаалийн албан татвараас чөлөөлсүгэй.</p>			



2 дугаар зүйл.Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан тоног төхөөрөмжийн жагсаалтыг Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем /БТКУС/-ийн ангиллын дагуу Засгийн газар батална.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2014 оны 01 дүгээр сарын 24-ний өдрөөс эхлэн 2014 оны 12 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 01 дүгээр
сарын 24-ний өдөр

Улаанбаатар
хот

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.“ДЦС-4” ТӨХК-ийн суурилагдсан хүчин чадлыг Т-120/130-130-8МО турбинаар өргөтгөх барилга угсралтын ажлыг гүйцэтгэхэд шаардагдах тоног төхөөрөмж, сэлбэг материал, багаж хэрэгслийг импортлоход нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2014 оны 01 дүгээр сарын 24-ний өдрөөс эхлэн 2014 оны 12 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 01 дүгээр
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Монгол Улсын Засгийн газар, Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага хооронд 2013 оны 11 дүгээр сарын



15-ны өдөр байгуулсан “Улаанбаатар хотын 4 дүгээр цахилгаан станцын үр ашгийг дээшлүүлэх төсөл”-ийн зээлийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2014 оны 01 дүгээр
сарын 16-ны өдөр

Дугаар 16

Улаанбаатар
хот

**Газар тариалангийн
үйлдвэрлэлийг эрчимжүүлэх
хөтөлбөрийн тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Газар тариалангийн салбарыг эрчимжүүлэн хөгжүүлж, тогтвортой хөгжлийг хангах, үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, алслагдсан бүс нутгийн газар тариаланг хөгжүүлэх зорилгоор дэвшилтэт технологид суурилсан техникийн шинэчлэлийг нэвтрүүлж, газрын өмчлөл, эзэмшил, ашиглалтыг сайжруулах, бордоо, ургамал хамгааллын бодисын хангалтыг нэмэгдүүлэх, таримлын зохистой сэлгээг нэвтрүүлэх замаар хөрсний үржил шимийг сайжруулах, хамгаалах, үрийн аж ахуйг хөгжүүлж, үр, сортын шинэчлэл хийх, газар тариалан, мал аж ахуйн хөгжлийн бодлогын уялдааг хангах зэрэг асуудлаар бодлого, хөтөлбөрийг боловсруулж Улсын Их Хурлын 2013 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/-т даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2014 оны 01 дүгээр
сарын 16-ны өдөр

Дугаар 17

Улаанбаатар
хот

Монгол судлалыг хөгжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол судлалыг хөгжүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/-т даалгасугай:

1/монгол судлалыг хөгжүүлэх бодлого боловсруулан хэрэгжүүлэх, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий Монгол судлалын үндэсний зөвлөлийг Монгол Улсын Ерөнхий сайдын дэргэд байгуулан ажиллуулах;

2/Монголын түүх, нийгэм, соёл, хэл, зан заншил, үндэсний баялаг өв сангаа судлах, хамгаалах, түгээн дэлгэрүүлэх, хойч үедээ өвлүүлэх, хилийн чанадад болон дотоодод монгол судлалыг тогтвортой хөгжүүлэхэд Монгол судлалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг чиглүүлж, холбогдох дүрэм, журмыг боловсруулан баталж мөрдүүлэх;

3/Монгол судлалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг Монгол судлалыг дэмжих сангийн чиг үүрэгтэй уялдуулж, Засгийн газрын 2012 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 56 дугаар тогтоолоор баталсан “Монгол судлалыг хөгжүүлэх Үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах;

4/Монгол судлалыг дэмжих сангийн хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт бүрэн тусгаж байх.

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо /Д.Батцогт/-нд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2014 оны 01 дүгээр
сарын 23-ны өдөр

Дугаар 20

Улаанбаатар
хот

Төрийн аудитын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Улсын Их Хурлын гишүүн Ш.Түвдэндорж нарын нэр бүхий гишүүдээс 2014 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн аудитын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2014 оны 01 дүгээр
сарын 23-ны өдөр

Дугаар 21

Улаанбаатар
хот

Үндсэн хуулийн цэцийн 2014 оны 01 дүгээр дүгнэлтийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. “Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 342 дугаар зүйлийн 342.1 дэх хэсгийн “Давж заалдах шатны шүүх ял оногдуулсан, эсхүл цагаатгагдсан этгээдийн гэм буруутай эсэх асуудлыг шийдвэрлэхдээ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн, эсхүл Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн гэж үзвэл энэ хуулийн 304 дүгээр зүйлд заасан журмын дагуу шүүгдэгч, цагаатгагдсан этгээд, хохирогчийн өмгөөлөгч гомдол гаргах, улсын

яллагч, эсхүл дээд шатны прокурор эсэргүүцэл бичих эрхтэй.” гэж заасны “... шүүгдэгч, цагаатгагдсан этгээд, хохирогчийн өмгөөлөгч гомдол гаргах ... эрхтэй.” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14/ дэх заалтын “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ... өөрийгөө өмгөөлөх, ... шүүхийн шийдвэрийг давж заалдах ... эрхтэй.” гэснийг зөрчсөн байна.” гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2014 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

2.Энэ тогтоолыг 2014 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2014 оны 01 дүгээр
сарын 29-ний өдөр

Дугаар 23

Улаанбаатар
хот

Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газраас 2013 оны 06 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд Газрын тосны тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Газрын тосны тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх тухайн асуудлаар хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр гаргах шаардлагагүй гэж үзсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2014 оны 01 дүгээр
сарын 29-ний өдөр

Дугаар 25

Улаанбаатар
хот

Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын гишүүн Раднаасүмбэрэлийн Гончигдоржийг Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлсүгэй.

2.Улсын Их Хурлын гишүүн Гаваагийн Батхүү, Дамдингийн Дэмбэрэл нарыг Тусгай хяналтын дэд хорооны гишүүнээр баталсугай.

3.Энэ тогтоолыг 2014 оны 01 дүгээр сарын 29-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2014 оны 01 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар 26

Улаанбаатар
хот

Нууц Протоколыг ил болгох тухай

Төрийн нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын “б” дэд заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Нөхцөл байдал өөрчлөгдсөний улмаас нууцлах шаардлагагүй болсон 1971 оны 7 дугаар сарын 29-ний өдөр байгуулсан “БНМАУ-д тусламж үзүүлж буй зөвлөлтийн мэргэжилтнүүдийг байраар хангах, үйлчлэх зорилгоор БНМАУ-д орон сууц болон хэрэгцээт соёл, ахуйн объектуудыг барих тухай БНМАУ-ын Засгийн газар, ЗСБНХУ-ын Засгийн газар хоорондын Протокол”-ыг төрийн нууцаас гаргаж, ил болгосугай.



2.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2014 оны 01 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар 27

Улаанбаатар
хот

**Монгол Улсын Их Хурлын 2009 оны
87 дугаар тогтоолын хавсралтад нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай**

Төрийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.10 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн “Гурав”-ын 3.3 дахь заалтын “агентлагт” гэсний өмнө “Шүүхийн ерөнхий зөвлөл”, “Үндэсний статистикийн хороо” гэж нэмсүгэй.

2.Уг дүрмийн “Гурав”-ын 3.7.2 дахь заалтын “Шүүхийн ерөнхий зөвлөл,” гэснийг, “Санхүүгийн зохицуулах” гэсний дараах “хороо, Үндэсний статистикийн” гэснийг, “Үндэсний аудитын газар” гэсний дараах “Үндэсний статистикийн хорооны” гэснийг тус тус хассугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 11 дүгээр
сарын 16-ны өдөр

Дугаар 374

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 5.3, 7.7-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:



1. “Байгаль орчны стратегийн болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний журам”-ыг 1 дүгээр, “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам”-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний аргачлалыг дэмжиж, уг аргачлалыг батлан хэрэгжүүлэхийг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюунд даалгасугай.

3. Энэхүү тогтоолоор баталсан журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюунд үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

**БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН
ХӨГЖЛИЙН САЙД**

С.ОЮУН

Засгийн газрын 2013 оны 374 дүгээр
тогтоолын 1 дүгээр хавсралт

**БАЙГАЛЬ ОРЧНЫ СТРАТЕГИЙН БОЛОН
ХУРИМТЛАГДАХ НӨЛӨӨЛЛИЙН
ҮНЭЛГЭЭНИЙ ЖУРАМ**

1. Журмын зорилго

1.1. Энэхүү журмын зорилго нь байгаль орчны стратегийн болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хийхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

2. Байгаль орчны стратегийн үнэлгээ хийх

2.1. Стратегийн үнэлгээг улсын болон бүс нутаг, салбарын хэмжээнд баримтлах бодлого, хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах явцад тухайн асуудлыг хариуцсан яам хийлгэнэ.

2.2. Байгаль орчны стратегийн үнэлгээ хийх явцад дараах зарчмыг баримтална:



2.2.1. бодлого, хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах эхний үе шатанд байгаль орчныг хамгаалах, ногоон хөгжлийн зорилтыг тодорхойлж, уг баримт бичигт тусгах;

2.2.2. байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдэл, сөрөг нөлөөллөөс зайлсхийх боломжит хувилбар болон хэрэгжүүлэхээс татгалзах хувилбарыг тодорхойлох;

2.2.3. бодлого, хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулахтай холбоотой шийдвэр, үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй, ил тод байлгах;

2.2.4. стратегийн үнэлгээний үр дүн, дүгнэлтийг судалгааны баримтад тулгуурлан боловсруулах;

2.2.5. оролцогч талууд стратегийн үнэлгээ хийх явцад хариуцлагатай хандах.

2.3. Стратегийн үнэлгээ хийхийн өмнө бодлого, хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг санаачлан боловсруулж байгаа яам болон стратегийн үнэлгээ хийх мэргэжлийн байгууллага нь нөлөөлөлд өртөх байгалийн нөөц, экосистем, хүн амын эрүүл мэндийн өнөөгийн төлөв байдлын үнэлгээний товч танилцуулга, байгаль хамгаалах, ногоон хөгжлийг хангах зорилт, стратегийн үнэлгээний ажлын удирдамжийн төслийг боловсруулж, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

2.4. Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь энэ журмын 2.3 дахь хэсэгт заасан бичиг баримтыг хүлээн авснаас хойш ажлын 10 хоногт багтаан стратегийн үнэлгээний ажлын удирдамжийн төсөлд санал, чиглэл өгнө.

2.5. Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас өгсөн санал, чиглэлийг үндэслэн бодлого, хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг санаачлан боловсруулагч салбарын яам стратегийн үнэлгээний ажлын удирдамжийг батална.

2.6. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 5.2-т заасны дагуу мэргэжлийн баг стратегийн үнэлгээг хийнэ.



2.7. Бодлого, хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг санаачлан боловсруулж байгаа яам нь стратегийн үнэлгээ хийх мэргэжлийн багийг тухай бүр бүрдүүлнэ.

2.8. Стратегийн үнэлгээ хийх мэргэжлийн баг нь хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах эхний үе шатанд стратегийн үнэлгээний хамрах хүрээг тодорхойлж, нөлөөлөлд өртөх байгалийн нөөц, экосистем, хүн амын эрүүл мэндийн өнөөгийн төлөв байдлын үнэлгээг хийж, байгаль орчныг хамгаалах, ногоон хөгжлийн зорилтыг тодорхойлно.

2.9. Стратегийн үнэлгээ хийх мэргэжлийн баг нь батлагдсан удирдамжийн дагуу стратегийн үнэлгээг хийж тайлан дүгнэлт гаргана. Тайлан, дүгнэлт нь дараах мэдээллийг агуулна:

2.9.1. бодлого, хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөний төслийн товч агуулга, түүний зорилго, зорилт, хэрэгжүүлэх гол арга хэмжээ;

2.9.2. нөлөөлөлд өртөх болон өртөж болзошгүй байгалийн нөөц, экосистемийн өнөөгийн төлөв байдал, хэтийн хандлага;

2.9.3. байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдэл, сөрөг нөлөөлөл, түүний үр дагавар, хуримтлагдах сөрөг нөлөөлөл;

2.9.4. сөрөг нөлөөллөөс зайлсхийх, бууруулах боломжит хувилбар болон хэрэгжүүлэхээс татгалзах хувилбар, тэдгээрийн байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөллийн харьцуулалт;

2.9.5. эрсдэл, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулахад чиглэсэн арга хэмжээ;

2.9.6. сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээг бүрэн гүйцэд хэрэгжүүлсэн тохиолдолд байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд үзүүлэх эерэг нөлөөлөл;

2.9.7. бодлого, хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө нь байгаль хамгаалах, ногоон хөгжлийг хангах зорилт болон тухайн асуудлаархи төрийн бодлого, хөтөлбөртэй нийцэж байгаа эсэх;



2.9.8. бодлого, хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад стратегийн үнэлгээний дүгнэлт (зөвлөмж)-ийн хэрэгжилтийг хянах арга зам, үнэлэх шалгуур үзүүлэлт.

2.10. Стратегийн үнэлгээний тайлан, дүгнэлт болон түүний үр дүнг тусгасан бодлого, хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөний төслийг тухайн баримт бичгийг санаачлан боловсруулж байгаа яам нь байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

2.11. Энэ журмын 2.10-т заасан баримт бичгийг байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь өөрийн байгууллагын цахим хуудсанд байршуулж, ажлын 14 хоногийн хугацаанд олон нийтээс санал авах ажлыг зохион байгуулна.

2.12. Олон нийтийн санал, стратегийн үнэлгээний тайлан, түүний үр дүнг бодлого, хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөнд хэрхэн тусгасан тухай тайлан, дүгнэлтийн төслийг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 4.2-т заасан мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж, дүгнэлт гаргуулна.

2.13. Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн стратегийн үнэлгээний дүгнэлтийг тухайн бодлого, хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг хэлэлцэх Засгийн газрын хуралдаанд хамтатган танилцуулна.

2.14. Засгийн газраас баталсан бодлого, хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөнд байгаль орчны стратегийн үнэлгээний дүгнэлтийг заавал хавсаргана.

2.15. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь батлагдсан бодлого, хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг Засгийн газарт оруулж болно.

2.16. Засгийн газраас баталсан бодлого, хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах тохиолдолд тухайн хэсэгт стратегийн үнэлгээг хийх бөгөөд үнэлгээ хийхтэй холбоотой харилцааг энэ журмаар зохицуулна.

2.17. Стратегийн үнэлгээ хийхтэй холбогдон гарах зардлыг бодлого, хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг санаачлан боловсруулж байгаа яам нь хариуцана.



2.18. Стратегийн үнэлгээтэй холбогдон гаргасан маргааныг холбогдох хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

3. Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хийх

3.1. Тодорхой бүс нутгийн хэмжээнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас хэрэгжүүлж байгаа хэд хэдэн төслийн хуримтлагдах нөлөөллийн үнэлгээг байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 6.3-т заасны дагуу мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор хийнэ.

3.2. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь үнэлгээ хийх мэргэжлийн байгууллагыг тухай бүр нээлттэй шалгаруулалтаар сонгоно.

3.3. Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хийх ажлын даалгаврыг байгаль орчны болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

3.4. Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хийх мэргэжлийн байгууллага нь батлагдсан ажлын даалгаврын дагуу үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмж бүхий тайлан гаргах ба тайлан нь дараах мэдээллийг агуулна:

3.4.1. тухайн бүс нутгийн байгаль орчны өнөөгийн төлөв байдлын тодорхойлолт;

3.4.2. тухайн бүс нутгийн байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд үзүүлсэн болон үзүүлж байгаа гол сөрөг нөлөөллүүд, тэдгээрийн үр дагаврын тодорхойлолт;

3.4.3. хуримтлагдах нөлөөллийн эрчим, цар хүрээ (цаг хугацаа, орон зай), тархалт;

3.4.4. хуримтлагдах нөлөөллийн эх үүсвэрүүд, түүнийг хариуцах этгээд, тэдгээрийн нөлөөлөлд эзлэх хувь хэмжээ;

3.4.5. сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, зардлын тойм, тэдгээрийн хувилбарууд;



3.4.6. хуримтлагдсан сөрөг нөлөөллөөс үүдэн бий болсон байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндийн хохирлын үнэлгээ;

3.4.7. цаашид авах арга хэмжээний төлөвлөгөө, түүний хэрэгжилтэд хяналт тавих шалгуур үзүүлэлтүүд;

3.4.8. нөлөөлөлд өртсөн бүс нутаг дахь олон нийтийн хэлэлцүүлгийн үр дүн;

3.4.9. дүгнэлт, зөвлөмж.

3.5. Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний тайланг үнэлгээ хийсэн мэргэжлийн байгууллага нь байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

3.6. Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний тайлангийн хураангуй болон дүгнэлт (зөвлөмж)-ийг ажлын 14 хоногийн хугацаанд өөрийн байгууллагын цахим хуудсанд байршуулж, олон нийтийн саналыг авна.

3.7. Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний тайланг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 4.2-т заасан мэргэжлийн зөвлөл хэлэлцэн дүгнэлт гаргаж, тухайн бүс нутагт цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмжийн хамт байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад танилцуулна.

3.8. Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хийхэд шаардагдах зардлыг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 6.5-т заасны дагуу төсөл хэрэгжүүлэгч хариуцна.

3.9. Шаардлагатай тохиолдолд үнэлгээний ажилд шаардагдах зардлыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага урьдчилан гаргаж болох бөгөөд уг зардлыг үнэлгээний дүгнэлтэд үндэслэн хуримтлагдсан нөлөөллийн цар хүрээ, эзлэх хувь хэмжээг харгалзан төсөл хэрэгжүүлэгчээс гаргуулна.

3.10. Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээтэй холбоотой гарсан маргааныг холбогдох хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.



Засгийн газрын 2013 оны 374 дүгээр
тогтоолын 2 дугаар хавсралт

БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ЖУРАМ

1. Журмын зорилго

1.1. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх, түүнтэй холбогдсон шийдвэр гаргах, оролцогч талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

2. Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ

2.1. Байгаль орчны төлөв байдлын үнэлгээг төслийн анхан шатны баримт бичгийг боловсруулах үе шатанд төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн хүрээнд хийнэ.

2.2. Энэ журмын 2.1-д заасан үнэлгээг дараах төсөлд хийлгэнэ:

2.2.1. байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас ерөнхий үнэлгээ хийгдэх төсөл;

2.2.2. ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуул, ашиглалтын төсөл;

2.2.3. бусад шаардлагатай төсөл.

2.3. Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайланд төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй газар нутгийн байгаль орчны төлөв байдал (усан орчин, цаг уур, геологи, гидрогеологи, геоморфологи, уур амьсгалын нөхцөл, агаарын чанар, хөрс, ургамал, амьтан г.м) болон төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй иргэдийн суурьшил, түүх, соёлын үнэт зүйлсийн талаархи мэдээлэл, газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдсан байдал зэрэг асуудлыг тусгасан байна.

2.4. Газрын тос, ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, байгалийн хий, аюултай хог хаягдал хадгалах, боловсруулах, устгах, тусгай хамгаалалттай газар нутаг, түүний орчны бүс болон ой, усны сан бүхий газрын хамгаалалтын бүсэд хэрэгжүүлэх төслийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээнд үнэлгээ хийж байгаа мэргэжлийн байгууллага нь



байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас санал авна.

2.5. Байгаль орчны төлөв байдлын үнэлгээтэй холбогдон гарах зардлыг төсөл хэрэгжүүлэгч хариуцна.

2.6. Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийхтэй холбогдон гарсан маргааныг захиалагч, гүйцэтгэгч нарын хооронд байгуулсан гэрээгээр зохицуулна.

3. Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ, түүнд тавигдах шаардлага

3.1. Төсөл хэрэгжүүлэгч Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7.3-т зааснаас гадна дараах баримт бичгийг бүрдүүлэн, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эсхүл аймаг, нийслэлийн байгаль орчны албанд хандан ерөнхий үнэлгээ хийлгэнэ:

3.1.1. энэ журмын 2.4-т заагдсан төслийн хувьд төсөл хэрэгжих нутаг дэвсгэрт хийгдсэн байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлан;

3.1.2. төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллагын гэрчилгээ, газар ашиглах, эзэмших, ашигт малтмал хайх, ашиглах талаархи эрх бүхий байгууллагын шийдвэр эсхүл тусгай зөвшөөрөл, түүний эрхийг шилжүүлсэн тухай баримтын хуулбар;

3.1.3. төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан байдлын тодорхойлолт;

3.1.4. газрын тос, байгалийн хий, ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын төсөлд хайгуулын ажлын батлагдсан төлөвлөгөө, тухайн сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын санал;

3.1.5. аймаг, нийслэлийн байгаль орчны албанаас ерөнхий үнэлгээ хийгдэх төслийн хувьд төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны өнөөгийн төлөв байдлын тодорхойлолт.

3.2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн хавсралтад заагдсан аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар



хариуцаж байгаа төслийг хэрэгжүүлснээс үүдэн гарах сөрөг нөлөөллийг байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний түвшинд тогтоох боломжгүй, нэмэлт судалгаа, шинжилгээ хийх зайлшгүй шаардлагатай бол байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

3.3. Энэ журмын 3.2-т зааснаас бусад тохиолдолд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7.4.1, 7.4.2-т заасны дагуу дүгнэлт гаргана.

4. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, түүнд тавигдах шаардлага

4.1. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу эрх авсан аж ахуйн нэгж гүйцэтгэх бөгөөд аж ахуйн нэгжийн удирдлага, мэргэжилтнүүд нь үнэлгээ хийлгэх төсөл хэрэгжүүлэгчтэй ашиг сонирхлын зөрчилгүй байна.

4.2. Үнэлгээ хийх эрхийг дор дурдсан чиглэлээр олгох бөгөөд нэг аж ахуйн нэгж хэд хэдэн чиглэлээр эрх авч болно:

4.2.1. уул уурхайн салбар;

4.2.2. дэд бүтцийн салбар;

4.2.3. үйлдвэр, хөдөө аж ахуйн салбар;

4.2.4. үйлчилгээний салбар.

4.3. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх эрх авахыг хүссэн аж ахуйн нэгжийн удирдлага байгаль орчны чиглэлээр мэргэшсэн, тухайн салбарт 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай байна.

4.4. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд 3-аас дээш удаа техникийн болон мэргэжлийн шинжтэй алдаа гаргасан, ерөнхий үнэлгээгээр тогтоосон нөхцөл болзол, батлагдсан аргачлалын дагуу гүйцэтгээгүй, шаардлагатай материалыг бүрдүүлээгүй, төслийн техник технологийн шийдлийг байгаль орчинд халгүй байхаар санал болгож, шаардлагыг тодорхойлоогүй нь үнэлгээний шинжилгээгээр тогтоогдсон тохиолдолд үнэлгээ хийх эрхийг хугацаанаас нь өмнө цуцална.



4.5. Мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтээс гадна дараах мэдээллийг хянан үзэж байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх эрхийн хугацааг сунгах эсэхийг шийдвэрлэнэ:

4.5.1. тухайн аж ахуйн нэгж ус, хөрс, ургамал, амьтан, уур амьсгал, агаарын бохирдлын асуудал хариуцсан мэргэжлийн орон тооны ажилтантай эсэх (харъяалагдах нийгмийн даатгалын хэлтсийн тодорхойлолт, ажилтнуудын нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар);

4.5.2. эрхийн хугацаанд хийсэн нарийвчилсан үнэлгээний ажлын үр дүн, мэдээллийн санд тайлан, мэдээг тогтмол оруулж, үнэлгээний ажилд мэргэжлийн экспертүүдийг байнга татан оролцуулдаг эсэх;

4.5.3. эрх бүхий аж ахуйн нэгж нь байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийхэд үндсэн үйл ажиллагаагаа чиглүүлж ажилласан эсэх зэрэг болно.

4.6. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 8.4-т заасан асуудлыг багтаасан нөлөөллийн үнэлгээний судалгаа, нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, техник, технологийн шийдлийн зөвлөмжийг агуулсан тайлан болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөнөөс бүрдэнэ.

4.7. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний судалгааны үр дүн нь үнэлгээний тайлан, батлагдсан байгаль орчны менежментийн төлөвлөгөө байна. Тайлан, менежментийн төлөвлөгөөний бүтэц, агуулгын талаар үнэлгээний аргачлалд тодорхой тусгана.

4.8. Томоохон хэмжээний дулааны цахилгаан станц, химийн хортой болон аюултай бодис, цацраг идэвхт бодис, аюултай хог хаягдлыг хадгалах, боловсруулах төслийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний судалгаанд орчныг бохирдуулах бодисын тархалтын хүрээг тогтоосон судалгааны үр дүнг заавал тусгасан байна.

4.9. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний судалгааны явцад бүрдүүлсэн хээрийн бичиглэлийн хуудас, маягтууд, тайлбар бүхий фото зургууд, видео бичлэг, дагалдах мэдээллүүдийн хавсралт, загварчлал, тооцооллуудын эх хувийг үнэлгээ хийсэн эрх бүхий аж ахуйн нэгж өөрийн мэдээллийн санд хадгалах бөгөөд шаардлагатай тохиолдолд үнэлгээний мэргэжлийн зөвлөлийн хуралд танилцуулна.



4.10. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний судалгааны явцад төсөл хэрэгжиж буй орчинд хуримтлагдах нөлөөлөл үүсгэж буй эх үүсвэр, бусад төслүүдийн судалгааг хийж, нөлөөллийн шинж чанарыг тодорхойлсон байна.

4.11. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний явцад олон нийтийн оролцоог хангахдаа Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 18.5-т заасан журмыг баримтална.

4.12. Нарийвчилсан үнэлгээний тайланг Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхэд уг тайланг боловсруулсан аж ахуйн нэгжийн удирдлага, мэргэжилтнүүд (ус, хөрс, ургамал, амьтан, уур амьсгал, орчны бохирдлын асуудал хариуцсан мэргэжилтэн), төсөл хэрэгжүүлэгч байгууллагын удирдлагыг заавал оролцуулна.

4.13. Мэргэжлийн зөвлөлийн хурлаас 3-оос доошгүй хоногийн өмнө хэлэлцүүлэх тайлангийн талаархи дэлгэрэнгүй мэдээллийг Мэргэжлийн зөвлөлийн гишүүдэд хүргүүлсэн байна.

4.14. Хэрэгжиж байгаа төслийн техник эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ), зураг төсөл шинэчлэгдэх, өргөтгөл хийх (техник, технологийг шинэчлэх, түүхий эд, байгалийн нөөц баялгийг ашиглах хэмжээ, хүчин чадал, газрын байрлал өөрчлөх болон байгаль орчны аудитын зөвлөмжөөр нэмэлт тодотгол хийлгэх шаардлагатай гэж үзсэн зэрэг) болон тухайн төсөлтэй холбогдох харилцааг зохицуулах эрх зүйн гол баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдолд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд нэмэлт тодотгол хийнэ.

4.15. Байгалийн нөөц ашиглан үйл ажиллагаа явуулж буй төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд нэмэлт тодотгол хийлгэхдээ тухайн төсөлд хийлгэсэн байгаль орчны хуваарьт аудитын зөвлөмж, тайланг ирүүлнэ.

4.16. Нэмэлт тодотголыг ерөнхий үнэлгээгээр өгөгдсөн чиглэл, хуваарийн дагуу хийнэ.

5. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

5.1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд төслийн гол болон болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг



бууруулах, арилгах арга хэмжээг бүрэн тусгахаас гадна дараах зүйлийг тусгана:

5.1.1. уул уурхайн төслийн хаалтын үед авч хэрэгжүүлэх гол арга хэмжээ, хамрах хүрээ;

5.1.2. байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүний нөөц, байгаль орчны удирдлагын бүтэц, зохион байгуулалт;

5.1.3. байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үр дүнг холбогдох төрийн байгууллага, олон нийтэд тайлагнах төлөвлөгөө;

5.1.4. нүүлгэн шилжүүлэх, нутгийн иргэдийн эрүүл мэнд, эрх ашиг, амьжиргаа, соёлын өвийг хамгаалах болон бусад төлөвлөлттэй хэрхэн уялдсан байдал.

5.2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг тусгах ба дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ нь дараах зарчмыг хангасан байна:

5.2.1. дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх газар нь тухайн нөлөөлөлд өртсөн газартай адил байгаль экологийн нөхцөлтэй байх;

5.2.2. дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний зардлын тооцоо нь үнэн бодит судалгаа, мэдээлэлд үндэслэсэн байх;

5.2.3. дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ нь төсөл хэрэгжүүлэгчийн зүгээс хуулиар хүлээсэн нөлөөллийг бууруулах, арилгах, нөхөн сэргээх үүргээс зайлсхийх нөхцөл болохгүй байх;

5.2.4. дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө, үр дүнг тайлагнах хэлбэр, хяналт тавих механизм зэргийг тодорхой тусгасан байх;

5.3. Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний улсын нэгдсэн бүртгэлийг байгаль орчны нөлөөллийн үнэлгээний мэдээллийн санд оруулна.



5.4. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний салшгүй бүрэлдэхүүн хэсэг болох орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг төслийн бүх үе шатанд хэрэгжүүлэх ба уг хөтөлбөрт дараах асуудлыг нарийвчлан тусгасан байна:

5.4.1. нөлөөлөлд өртөж болзошгүй байгаль орчин, хүний эрүүл мэнд, нийгмийн төлөв байдлын суурь мэдээлэл ба төсөл хэрэгжсэнээр түүнд гарч болзошгүй тоон ба чанарын өөрчлөлт;

5.4.2. нөлөөллийг багасгах, арилгах, нөхөн сэргээх, хоргүйжүүлэх, саармагжуулах арга хэмжээний үр дүнг хэмжих тоон ба чанарын үзүүлэлтүүд;

5.4.3. төсөл хэрэгжүүлэгчийн дагаж мөрдөх Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын гэрээ, Монгол Улсын хууль тогтоомж, стандарт болон хэм хэмжээний үзүүлэлтүүд;

5.4.4. хяналт-шинжилгээ хийх шаардлагатай байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, нөхөн сэргээх арга хэмжээнүүд, нөлөөллийг хэмжих хэмжигдэхүүн;

5.4.5. сорьц авах, хэмжилт хийх, түүнд дүн шинжилгээ хийх арга, байршил, хугацаа, давтамж.

5.5. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэнд, нийгэмд урьдчилан тооцоолоогүй сөрөг нөлөөлөл үзүүлсэн нь тогтоогдсон тохиолдолд холбогдох төрийн байгууллагууд нь төсөл хэрэгжүүлэгчээс нэн даруй арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг шаардана.

5.6. Төсөл хэрэгжүүлэгч энэ журмын 5.5-т заасан шаардлагыг биелүүлээгүй, сөрөг нөлөөллийг арилгах талаар тодорхой арга хэмжээ аваагүй тохиолдолд холбогдох төрийн байгууллага уг төслийн үйл ажиллагааг тухайн сөрөг нөлөөллийг арилгах хүртэл түр түдгэлзүүлнэ.

5.7. Төсөл хэрэгжүүлэгч нь нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний хүрээнд боловсруулан батлагдсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тулгуурлан тухайн жилд хэрэгжүүлэх менежментийн төлөвлөгөөг боловсруулан, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулна. Уг төлөвлөгөөг шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагатай хамтран боловсруулна.



5.8. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг ажлын 21 хоногийн дотор багтаан шийдвэрлэнэ.

5.9. Холбогдох төрийн байгууллага нь орчны хяналт-шинжилгээгээр илэрсэн нөлөөллийг бууруулах нэмэлт арга хэмжээг тухайн жилийн менежментийн төлөвлөгөөнд тусгаагүй гэж үзвэл батлахаас татгалзаж, зохих засвар, өөрчлөлт хийхийг шаардах эрхтэй.

5.10. Өмнөх жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт нь хангалтгүй бол дараа жилийн менежментийн төлөвлөгөөг батлахгүй байх үндэслэл болно.

5.11. Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөө батлуулаагүй, холбогдох баталгааны хөрөнгийг байршуулалгүйгээр төслийн үйл ажиллагааг эхлэх, үргэлжлүүлэх эрхгүй.

5.12. Тухайн төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний судалгааны үр дүнг үндэслэн боловсруулсан байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь 5 жилээс дээшгүй хугацаатай байх бөгөөд түүнээс олон жил үргэлжлэх төслийн хувьд менежментийн төлөвлөгөөг 5 жил тутамд шинэчлэн боловсруулж батлуулна.

5.13. Тухайн төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлагдсаны дараа байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв болон орон нутгийн захиргааны байгууллага нь төсөл хэрэгжүүлэхийг албан бичгээр зөвшөөрнө.

6. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний шинжилгээ

6.1. Төсөл хэрэгжүүлэгч болон үнэлгээ хийсэн мэргэжлийн байгууллага хамтран эцэслэн боловсруулсан нарийвчилсан үнэлгээний тайлан, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад батлуулахаар хүргүүлнэ.

6.2. Шаардлагатай тохиолдолд ерөнхий шинжээчийн шийдвэрээр үнэлгээний шинжилгээний ажилд туслах хөндлөнгийн шинжээчийг томилж болно.



6.3. Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын шинжээч төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, байгаль орчны менежментийн төлөвлөгөө, түүнд хийсэн үнэлгээний шинжилгээний дүгнэлт, шийдвэрийн төслийг мэргэжлийн зөвлөлийн хуралд оруулж хэлэлцүүлнэ.

6.4. Мэргэжлийн зөвлөл нь үнэлгээний шинжилгээ хийсэн шинжээчийн дүгнэлт, шийдвэрийн төсөл, үнэлгээний тайлан, байгаль орчны менежментийн төлөвлөгөөтэй танилцаж дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

6.4.1. зарим шаардлагатай засвар, нэмэлт тодруулгыг тусгаж үнэлгээний тайлан, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг баталж, төсөл хэрэгжүүлэхийг албан бичгээр зөвшөөрөх;

6.4.2. байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардал бодит бус, нэмэлт судалгаа, мэдээлэл шаардлагатай гэж үзсэн тохиолдолд батлахаас татгалзаж, төсөл хэрэгжүүлэгчид албан бичгээр буцаах;

6.4.3. төсөл нь байгаль орчин, хүний эрүүл мэндэд нэн халтай, нөхөх боломжгүй хохирол учруулна гэж үзсэн тохиолдолд төслийг хэрэгжүүлэхээс татгалзах.

6.5. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэрийг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7.6-д заасны дагуу Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын ерөнхий шинжээч гарын үсэг зурж албажуулна .

7. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах, түүнийг хянаж хүлээн авах

7.1. Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд дотоод хяналт тавих үүрэг бүхий оролцогч талуудын төлөөллийг оролцуулсан хамтарсан ажлын хэсгийг байгуулж болно.

7.2. Төсөл хэрэгжүүлэгчийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний явцын болон гүйцэтгэлийн хяналтыг байгаль



орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас хяналт тавьж, газар дээр нь ажиллаж хэмжилт, судалгаа хийнэ.

7.3. Төсөл хэрэгжүүлэгч нь тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг төсөл хэрэгжиж буй аймаг, нийслэлийн байгаль орчны газарт хүргүүлж, төлөвлөгөөний хэрэгжилтийг газар дээр нь шалгуулж ажлын хэсгийн дүгнэлт гаргуулна.

7.4. Төсөл хэрэгжүүлэгчийн жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг газар дээр нь шалгаж дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг аймаг, нийслэлийн байгаль орчны албаар ахлуулж, аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар байгуулна.

7.5. Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан, түүнд хийсэн ажлын хэсгийн дүгнэлтийг хавсарган дараа жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад 12 дугаар сарын 20-ны дотор ирүүлнэ.

8. Байгаль орчны үнэлгээний мэдээллийн сан, хянан магадлагаа

8.1. Үнэлгээний мэдээллийг нээлттэй болгох зорилгоор байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага байгаль орчны нөлөөллийн үнэлгээний мэдээллийн нэгдсэн санг байгуулна. Мэдээллийн сан нь дараах мэдээллийг агуулна:

8.1.1. үнэлгээтэй холбоотой хууль эрх зүйн бүх баримт бичиг;

8.1.2. байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайлангийн товч танилцуулга;

8.1.3. хянан магадалгааны дүгнэлт, түүний мөрөөр авсан арга хэмжээ, түүний биелэлт;

8.1.4. жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, тайлан, баталгааны тусгай дансны мэдээллүүд;



8.1.5. улсын байцаагчийн хяналт шалгалтын мэдээ, түүний мөрөөр авсан арга хэмжээ, биелэлт.

8.2. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн танилцуулгыг үнэлгээ хийсэн эрх бүхий аж ахуйн нэгж мэдээллийн санд оруулах ба эх тайланг байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын архивт 5 жил хадгална.

8.3. 5-аас дээш жил хадгалсан үнэлгээний эх тайланг Байгаль орчны мэдээллийн сангийн төв архивт шилжүүлнэ.

8.4. Хянан магадлагаа хийх ажлын хэсгийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох мэргэжлийн хүмүүсийг оролцуулан тухай бүр томилон ажиллуулах ба ажлын удирдамжийг батална. Удирдамжид дараах асуудлыг тусгана:

8.4.1. хянан магадлагаа хийх хугацаа;

8.4.2. хянан магадлагаа хийх ажлын цар хүрээ;

8.4.3. хянан магадлагааны аргачлал;

8.4.4. бусад асуудал.

8.5. Хянан магадлагааны дүгнэлтийг холбогдох талуудыг оролцуулсан үнэлгээний мэргэжлийн зөвлөлийн өргөтгөсөн хурлаар хэлэлцүүлж болно.

9. Мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагаа

9.1. Мэргэжлийн зөвлөл нь байгаль орчин, нийгэм, эрүүл мэнд, эдийн засаг, хөгжлийн салбарын төлөөллийг оролцуулсан 10-аас доошгүй гишүүний бүрэлдэхүүнтэй байх ба гишүүд нь тухайн чиглэлээрээ 10-аас дээш жил ажилласан туршлагатай байна.

9.2. Мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн нь төр, төрийн бус болон хувийн хэвшлийн төлөөллөөс бүрдэх бөгөөд зөвлөлийн гишүүн өөрийн салбарын эрх ашгийг төлөөлж ажиллахгүй.

9.3. Мэргэжлийн зөвлөлийг ерөнхий шинжээч даргална.



9.4. Мэргэжлийн зөвлөл нь сард 1 удаа хуралдах бөгөөд гишүүдийн олонхи оролцсон тохиолдолд хуралдааныг хүчин төгөлдөр гэж үзнэ.

9.5. Мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт нь гишүүдийн олонхи нь гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно. Эсрэг саналыг мөн дүгнэлтэд тусгана.

9.6. Тухайн төслийн болон үнэлгээний ажлын цар хүрээ, онцлогоос хамааран мэргэжлийн зөвлөлийн хуралд холбогдох чиглэлийн мэргэжилтнийг татан оролцуулж болно.

9.7. Мэргэжлийн зөвлөл тайлангаа улирал бүрийн эхний 7 хоногт байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулна. Тайланд өнгөрсөн улиралд дүгнэлт гаргасан төсөл, тусгай зөвшөөрлийн жагсаалт, гаргасан шийдвэрийн талаар товч тусгана.

9.8. Мэргэжлийн зөвлөлийн гишүүдэд мөнгөн урамшуулал олгох асуудлыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн шийдвэрлэнэ.

9.9. Мэргэжлийн зөвлөлийн гишүүн хүндэтгэх шалтгаангүйгээр зөвлөлийн хуралд жилд 3 удаа оролцоогүй тохиолдолд тухайн гишүүнийг хасах саналыг ерөнхий шинжээч байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд тавьж шийдвэрлүүлнэ.

9.10. Мэргэжлийн зөвлөл нь ирц бүрдээгүйгээс удаа дараа хуралдаж чадаагүй тохиолдолд гишүүдийн бүрэлдэхүүнийг солих саналыг ерөнхий шинжээч байгаль орчны асуудал хариуцсан Засгийн газрын гишүүнд тавьж шийдвэрлүүлнэ.

9.11. Мэргэжлийн зөвлөлийн гишүүн нь ашиг сонирхлын зөрчилгүй байх ба холбогдох хуулийн дагуу энэ асуудлаар мэдэгдэл гаргаж өгнө.

9.12. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээтэй холбоотой гаргасан маргааныг холбогдох хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 11 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар 389

Улаанбаатар
хот

Төлөвлөгөө батлах тухай

Усны тухай хуулийн 9.1.1-ийг үндэслэн, Улсын Их Хурлын 2010 оны 24 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Улсын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө”-г хавсралт ёсоор баталсугай.

2. Улсын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх нэгдсэн бодлого, салбар дундын болон бүс нутгийн зохицуулалтаар хангаж ажиллахыг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюун, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Усны үндэсний хорооны нарийн бичгийн дарга Ц.Бадрах нарт даалгасугай.

3. Улсын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусгаж, гадаадын зээл, тусламж, төсөл хөтөлбөртэй уялдуулан санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд Ч.Улаан, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюун, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

**БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН
ХӨГЖЛИЙН САЙД**

С.ОЮУН

Засгийн газрын 2013 оны 389 дүгээр
ТОГТООЛЫН ХАВСРАЛ

МОНГОЛ УЛСЫН УСНЫ НӨӨЦИЙН НЭГДСЭН МЕНЕЖМЕНТИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Үйл ажиллагаа	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэгч	Хугацаа	Санхүүжилтийн эх үүсвэр
		1. Хүн амыг баталгаат, эрүүл аюулгүй усаар хангах үндсэн зорилтын хүрээнд:				
1.1	Унд-ахуйн ус хангамжийн эх үүсвэрт эрүүл ахуйн бүс тогтоож, дэглэмийг мөрдүүлэх.	Улаанбаатар хот, 21 аймаг болон томоохон суурин газрууд болох Өвөрхангай аймгийн Хархорин, Сэлэнгэ аймгийн Сайхан, Баянгол, Хэнтий аймгийн Бор-Өндөр, Дорноговь аймгийн Замын үүд, Дархан-Уул аймгийн Шарын гол, Өмнөговь аймгийн Ханбогд, Цогтэций сумдын ус хангамжийн одоо байгаа болон шинэ эх эрүүл ахуйн бүс тогтоож, дэглэмийг мөрдүүлнэ.	БОНХЯ, СГЗ, аймаг, нийслэлийн ЭДТТ	БХБЯ, УХААЯ, ЭМЯ, МХЕГ, ОБЕГ	2014-2021	- Улсын төсөв - Орон нутгийн төсөв
	Усны нөөцийн эрэл хайгуул хийж, нөөцийг баталгаажуулах	Улаанбаатар хотын шинэ суурьшлын бүсүүдийн ус хангамжийн эх үүсвэрийн хайгуул судалгаа хийж нөөцийг баталгаажуулна. Туул усан цогцолборын ТЗҮ-ийн урьдчилсан судалгаа хийнэ.				- Улсын төсөв - Орон нутгийн төсөв - Гадаадын зээл Тусламж - Концесс
1.2		Говь-Сүмбэр, Дундговь, Дорноговь, Булган, Баян-Өлгий аймгууд болон бусад томоохон суурин газруудын төвийн ус хангамжийн эх үүсвэрийн хайгуул судалгаа хийж нөөцийг баталгаажуулна. "Туул усан цогцолбор"-ийн ТЗҮ болон зураг төсөл боловсруулж, хэрэгжүүлнэ. Аймгийн төвүүдийн ус хангамжийн	БОНХЯ	ЭЗХЯ, СЯ, СГЗ	2014-2021	Орон нутгийн төсөв
						Улсын төсөв



№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Үйл ажиллагаа	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэгч	Хугацаа	Санхүүжилтийн эх үүсвэр
		<p>эх үүсвэрийг шинэчилж, халдваргүйжүүлэх төхөөрөмж суурилуулж дотоодын хяналтыг тогтмолжуулна.</p> <p>Тайширын усан цахилгаан станцын усан сангаас ус дамжуулах хоолой татаж, Алтай хотын ус хангамжийг сайжруулна.</p> <p>Улаанбаатар хотын Багануур дүүрэг Төв аймгийн Алтанбулаг, Дорноговь аймгийн Замын-Үүд, Сэлэнгэ аймгийн Цагаан нуур, Хөтөл, Баянгол, Өмнөговь аймгийн Ханбогд, Цогтцэций сумдын ус хангамжийн эх үүсвэрийг шинэчилнэ.</p>				<p>-Улсын төсөв -Гадаадын зээл тусламж</p> <p>Улсын төсөв</p>
1.3	Ус хангамжийн шугам сүлжээг өргөтгөх, ус түгээх байрын шинэчлэх, ус түгээх байрын тоог нэмэгдүүлэх	<p>Улаанбаатар хотын ус түгээх сүлжээг өргөтгөж, ус түгээх байрны тоог 400-аар нэмэгдүүлнэ.</p> <p>Аймгийн төвүүдэд болон Өвөрхангай аймгийн Хархорин, Хэнтий аймгийн Бор-Өндөр, Дорноговь аймгийн Замын Үүд, Дархан-Уул аймгийн Шарын гол, Сэлэнгэ аймгийн Сайхан, Баянгол, Өвөрхангай аймгийн Ханбогд, Цогтцэций сумдын ус түгээх сүлжээг өргөтгөнө.</p>	БХБЯ	ЭЗХЯ, СЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ, СГЗ	2014-2021	<p>-Улсын төсөв -Орон нутгийн төсөв -Гадаадын зээл тусламж -Хувийн болон бусад</p> <p>-Улсын төсөв -Орон нутгийн төсөв, -Гадаадын зээл тусламж -Хувийн болон бусад</p>



№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Үйл ажиллагаа	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэгч	Хугацаа	Санхүүжилтийн эх үүсвэр
1.4	Бохир ус цэвэрлэх байгууламжийг шинээр байгуулах, шинэчлэх, өргөтгөх	Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг өргөтгөн хүчин чадал, цэвэрлэгээний түвшинг нэмэгдүүлнэ. Монгол орны нөхцөлд тохирсон технологи бүхий бага оврын цэвэрлэх байгууламжуудыг байгуулна. Аймгийн төвүүд, Хэнтий аймгийн Бор-Өндөр, Дорноговь аймгийн Замын үүд, Дархан-Уул аймгийн Шарын гол, Сэлэнгэ аймгийн Сайхан, Баянгол, Өмнөговь аймгийн Ханбогд, Цогтцэций сумдын бохир ус цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, сэргээн засварлах ажлыг гүйцэтгэнэ.	БХБЯ	БОНХЯ, ЭЗХЯ, СЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ, СГЗ	2014-2021	-Улсын төсөв -Орон нутгийн төсөв -Гадаадын зээл тусламж -Хувийн болон бусад -Улсын төсөв -Гадаадын зээл тусламж
1.5	Бохир усны шугам сүлжээг шинэчлэх, өргөтгөх	Улаанбаатар хот, аймгийн төвүүд болон томоохон суурин газруудын ариутгах татуургын шугам сүлжээг өргөтгөн шинэчлэнэ.	БХБЯ	ЭЗХЯ, СЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ, СГЗ	2014-2021	-Улсын төсөв -Орон нутгийн төсөв -Гадаадын зээл тусламж -Хувийн болон бусад
1.6	Цэвэршүүлсэн бохир усыг дахин ашиглах	Цэвэршүүлсэн бохир усыг цахилгаан станцад ашиглах боломжийг судална. Шинээр баригдах орон сууцны болон бусад томоохон барилга байгууламжид саарал ус ашиглах технологийг нэвтрүүлнэ.	БОНХЯ	БХБЯ, ЭЗХЯ, СЯ, СГЗ	2014-2021	-Улсын төсөв -Гадаадын зээл тусламж -Хувийн болон бусад
1.7	Батлан хамгаалах салбарын анги, нэгтгэл,	Баянхонгор аймгийн Баянлиг, Завхан аймгийн Сонгино, Увс				



№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Үйл ажиллагаа	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэгч	Хугацаа	Санхүүжилтийн эх үүсвэр
	Хилийн боомтуудын ус хангамжийг сайжруулах	аймгийн Зүүнговь, Хэнтий аймгийн Дэлгэрхаан, Төв аймгийн Сэргэлэн сумд дахь Хил хамгаалах ерөнхий газрын харъяа хилийн цэргийн харуул, анги, заставын ус хангамжийг сайжруулах, усны чанарыг дээшлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж, худаг, уст цэгийг шинээр барьж ашиглалтад оруулна.	БХЯ, БОНХЯ	ЭЗХЯ, СЯ	2014-2021	Улсын төсөв
		Хилийн нийт 15 боомтын ус хангамж, ахуйн цэврийн байгууламжийн нөхцлийг сайжруулна. (Замын-үүд, Алтанбулаг, Гашуунсухайт, Шивээхүрэн, Боршоо, Бичигт, Ханги, Бургастай, Булган, Ханх, Зэлтэр, Хөвд, Ингэнсэвстэй, Уушиг, Хархоньт, Жаалшанд, Хэцүү-Уул, Сайнсүүж, Үзүүр-Ус, Хөжбулаг, Цагаан-Овоо, Баянтөхөм, Ламт, Холбоо Залаа, Бүдүүн мод, Авдрант, Арбулаг, Бага хүрээ, Өргөстэй, 171-р боомт, Хатан суудал)	БХЯ	СЯ	2014-2021	Улсын төсөв
1.8	Сумын төвүүдийн хүн амын унд-ахуйн ус хангамжийн эх үүсвэрт эрүүл ахуйн бүс тогтоож, дэглэмийг мөрдүүлнэ. Нийт 560 булаг шандын эхийг хашиж хамгаална.	Сумын төв, хөдөөгийн ус хангамжийн эх үүсвэрүүдэд онцгой болон энгийн, эрүүл ахуйн бүс тогтоож, дэглэмийг мөрдүүлнэ. Нийт 560 булаг шандын эхийг хашиж хамгаална.	БОНХЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ	ЭМЯ, СЯ, МХЕГ, ОБЕГ, СГЗ	2014-2021	Орон нутгийн төсөв
1.9	Сумын төвийн ус	2015 оныг дуустал 10 сумын төвд,	аймаг,	БОНХЯ,	2014-2021	Улсын төсөв

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Үйл ажиллагаа	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэгч	Хугацаа	Санхүүжилтийн эх үүсвэр
	Хангамжийн эх үүсвэрийн хайгуул, судалгаа хийж, усны нөөцийг тогтоох	800 цэгт, 2021 он дуустал 36 сумын төвд, 3380 цэгт газрын доорхи усны хайгуул судалгаа хийнэ.	нийслэлийн ЗДТГ, СГЗ	ЭЗХЯ, СЯ		
1.10	Сумын төв, хөдөөгийн хүн амын ус хангамжийн эх үүсвэрийг шинээр байгуулах, өргөтгөх, шинэчлэх	2015 оныг дуустал 15, 2021 он дуустал 36 сумын төвийн ус хангамжийн эх үүсвэрийг шинэчилнэ.	БХБЯ, УХААЯ	ЭЗХЯ, СЯ, ЗДТГ, СГЗ	2014-2021	Улсын төсөв
1.11	Сумдын төвд бохир ус цэвэрлэх бага оврын байгууламж шинээр барих, цэвэрлэсэн усыг дахин ашиглах шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлэх	2015 оныг дуустал 9, 2021 он дуустал 36 сумын төвд бохир ус цэвэрлэх бага оврын байгууламж шинээр барина.	БХБЯ	ЭЗХЯ, ЗДТГ, СГЗ	2014-2021	-Улсын төсөв -Гадаадын зээл тусламж
1.12	Ус цэвэршүүлэх, зөөлрүүлэх төхөөрөмжийг суурилуулж, тогтвортой ажиллагааг хангах замаар ундны усны чанарыг сайжруулах	Манай орны нөхцөлд тохирсон технологи бүхий ус цэвэршүүлэх, зөөлрүүлэх төхөөрөмжийн судалгаа хийж, шинээр суурилуулах буюу шинэчлэн солино.	СГЗ	БХБЯ, СЯ	2014-2021	Улсын төсөв
1.13	Аялал жуулчлал, амралт, сувиллын газруудын ус хангамжийн нөхцлийг сайжруулах	Хот суурин газраас алслагдмал байрлах аялал жуулчлалын баазууд, зочид буудлууд болон амралт сувиллын газруудын ус хангамжийг сайжруулна.	ССАЖЯ	ЭЗХЯ, МХЕГ, ОБЕГ, аймаг, нийслэлийн ЗДТГ, СГЗ	2014-2021	-Улсын төсөв -Орон нутгийн төсөв -Хувийн болон бусад
1.14	Аялал жуулчлал, амралт сувиллын газруудад бохир ус цэвэрлэгээний шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлэх	ТҮҮЛ, Тэрэлж, Орхон, Хэрлэн, Хархираа, Онон, Их тамир, Чулуут, Балж зэрэг голууд, Увс, Хяргас, Хар-Ус, Хөвсгөл, Өгий, Гурван нуур, Ганга, Тэрхийн цагаан нууруудын орчим жуулчны баазуудад бага оврын ус хангамж,	ССАЖЯ	ЭЗХЯ, МХЕГ, ОБЕГ, аймаг, нийслэлийн ЗДТГ, СГЗ	2014-2021	Хувийн болон бусад



№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Үйл ажиллагаа	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэгч	Хугацаа	Санхүүжилтийн эх үүсвэр
1.15	Рашаан түшиглэн амралт, сувиллын үйлчилгээг хөгжүүлэх	арилгах татуургын байгууламж, бохир ус цэвэрлэгээний шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлнэ. Шинээр нийт 12 рашааны ашиглалтыг сайжруулан, сувиллын чиглэлээр ашиглана.	ЭМЯ	ЭЗХЯ, МХЕГ, ОБЕГ, аймаг, нийслэлийн ЗДТГ	2014-2021	Хувийн болон бусад
2. Хөдөө аж ахуйн салбарыг хэрэгцээт усаар хангах зорилтын хүрээнд:						
2.1	Хөв цөөрөм, усан сөн байгуулах, худаг гаргах, газрын усны нөөцийн хайгуул, судалгаа хийх	2015 оныг дуустал 200 газарт, 2021 оныг дуустал 829 газарт хөв, цөөрөм шинээр байгуулах судалгаа хийнэ.	БОНХЯ	УХААЯ, ЭЗХЯ, МХЕГ, ОБЕГ, аймаг, нийслэлийн ЗДТГ, СГЗ	2014-2021	Улсын төсөв
2.2	Бэлчээрийн даац, ашиглалт, цөлжилтийн байдлыг харгалзан худаг гаргах, хөв цөөрөм шинээр байгуулах, сэргээн засварлах	2014-2015 онд 1200 худаг, 2016-2021 онд 6050 худаг шинээр гаргаж засварлана. 2014-2015 онд 14, 2016-2021 онд шинээр 125 хөв цөөрөм байгуулна.	УХААЯ	МХЕГ, ОБЕГ, аймаг, нийслэлийн ЗДТГ, СГЗ	2014-2021	Улсын төсөв
2.3	Уст цэгийн ашиглалт, засвар үйлчилгээг сайжруулах	Малчдын бүлгийг дэмжин ажиллаж 2015 он дуустал 150 бүлэг, 2016-2021 онд 900 бүлэг байгуулна.	УХААЯ	МХЕГ, ОБЕГ, аймаг, нийслэлийн ЗДТГ, СГЗ	2014-2021	-Улсын төсөв -Гадаадын зээл тусламж -Хувийн болон бусад
2.4	Эрчимжсэн фермерийн аж ахуйн ус хангамжийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх	Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хот орчмын фермерийн аж ахуйнууд байгуулна.	УХААЯ	Аймаг, нийслэлийн ЗДТГ, СГЗ	2014-2021	-Улсын төсөв -Хувийн болон бусад
2.5	Усалгаатай тариалан, хадлангийн талбайн усны эх үүсвэрийн хайгуул, судалгаа хийх	Усалтын систем шинээр байгуулах, сэргээн засварлах газрын хайгуул, судалгаа хийнэ.	БОНХЯ	УХААЯ, СЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ, СГЗ	2014-2021	Улсын төсөв

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Үйл ажиллагаа	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэгч	Хугацаа	Санхүүжилтийн эх үүсвэр
2.6	Усжуулалтын зориулалтаар боомт, усан сан байгуулах, сэргээн засварлах	2015 оны түвшинд 22 мянган га-д, 2021 оны түвшинд 32 мянган га талбайд усалгаа хийх хүчин чадал бүхий усан сангуудыг шинээр болон шинэчлэн засварлана.	УХААЯ	БОНХЯ, СЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ, СГЗ	2014-2021	-Улсын төсөв -Хувийн болон бусад
2.7	Усгалтын системийн толгойн барилга, гол сүлгүүд болон усгалтын системийг шинээр байгуулах, шинэчлэх	Шинээр байгуулах усгалтын системийн талбайг 2015 оныг эцэст 1400 га, 2021 оны түвшинд 10600 га-аар, сэргээн засварлах усгалтын системийн талбайг 2015 оны эцэст 7100 га, 2021 оны түвшинд 22500 га-аар тус тус нэмэгдүүлнэ.	УХААЯ	СЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ, СГЗ	2014-2021	-Улсын төсөв -Хувийн болон бусад
2.8	Усгалтын системийн ажиллалтын менежментийг сайжруулах	Усгалтын системийн менежментийн багийг дэмжиж 2015 оны түвшинд 20, 2021 оны эцэст 50 бүлэг байгуулна.	УХААЯ	СЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ, СГЗ	2014-2021	-Орон нутгийн төсөв -Гадаадын зээл тусламж
2.9	Усалгаатай тариалангийн агротехнологийг сайжруулах, усыг хэмнэлтэй зарцуулах технологи нэвтрүүлэх	Усалгаатай тариалангийн агротехнологийг сайжруулж, дуслын болон бороожуулах усалгааны шинэ технологиуд нэвтрүүлнэ. Монгол орны нөхцөлд тохирсон, ган зулад тэсвэртэй шилмэл сортын ургамлуудын тариалалтыг нэмэгдүүлнэ. Усалгааг хөрс хамгаалах технологигойг хослуулан ашиглахыг дэмжинэ.	УХААЯ	Аймаг, нийслэлийн ЗДТГ, СГЗ	2014-2021	Хувийн болон бусад
3. Үйлдвэр, уул уурхай, эрчим хүчний салбарыг хэрэгцээт усаар хангах үндсэн зорилтын хүрээнд:						
3.1	Томоохон үйлдвэрүүдийн усны эх үүсвэрийн хайгуул, судалгаа хийх	Улаанбаатар хотын Багахангай дүүрэг, Дорноговь аймгийн Сайншанд, Говь-Сүмбэр аймгийн Чойр хотуудад байгуулах	БОНХЯ	СЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ, СГЗ	2014-2021	-Улсын төсөв -Хувийн болон бусад



№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Үйл ажиллагаа	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэгч	Хугацаа	Санхүүжилтийн эх үүсвэр
3.2	Шинээр байгуулах аж үйлдвэрийн цогцолборуудын ус хангамжийн асуудлыг шийдвэрлэх	Улаанбаатар хот, Дорноговь аймгийн Сайншанд, Говь-Сүмбэр аймгийн Чойр хотуудад байгуулах үйлдвэрийн цогцолборуудын ус хангамжийн байгууламж барина.	УХААЯ	СЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ, СГЗ	2014-2021	-Улсын төсөв -Хувийн болон бусад
3.3	Зарим үйлдвэрийн ус хангамжийн эх үүсвэрийг хүн амын унд-ахуйн ус хангамжийн эх үүсвэрээс тусгаарлах	Дархан-Уул, Эрдэнэт, Улиастай, Зуунмод, Чойбалсан, Өндөрхайд, Улаангом, Сүхбаатар, Сайншанд хотууд дахь томоохон үйлдвэрийн ус хангамжийг унд-ахуйн уснаас тусгаарлана. Цэвэршүүлсэн бохир ус ашиглах асуудлыг судалж, хэрэгжүүлнэ.	БХБЯ, УХААЯ	Аймаг, нийслэлийн ЗДТГ, СГЗ	2015-2021	Хувийн болон бусад
3.4	Үйлдвэрийн бохир ус цэвэрлэх байгууламжийг тусгайлан байгуулах	Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй үйлдвэрүүдэд бага оврын урьдчилан цэвэрлэх байгууламж нэвтрүүлж, үйлдвэрийн бохир ус цэвэрлэх төвлөрсөн байгууламж барина.	БХБЯ, УХААЯ	БОНХЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ, СГЗ	2014-2021	-Гадаадын зээл -Тусламж -Хувийн болон бусад
3.5	Үйлдвэрийн цэвэршүүлсэн бохир усыг дахин ашиглах	Аймгийн төвүүд, томоохон сум суурин газруудад үйл ажиллагаа явуулж буй томоохон үйлдвэрүүдэд бага оврын урьдчилан цэвэрлэх байгууламж нэвтрүүлнэ.	УХААЯ	БОНХЯ, МХЕГ, ОБЕГ, аймаг, нийслэлийн ЗДТГ, СГЗ	2014-2021	Хувийн болон бусад

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Үйл ажиллагаа	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэгч	Хугацаа	Санхүүжилтийн эх үүсвэр
3.6	Уул уурхайн ус хангамжийн эх үүсвэрийн хайгуул, судалгаа хийх	Оюу Толгой, Асгат, Цагаан суварга, Таван толгой, Нарийн Сүхэйт, Бороо, Шивээ овоо, Олон овоот, Мардай, Гурванбулаг, Бүрэнхаан, Шивээ овоо, Дулаан-Уул, Хараатын ордуудад ус хангамжийн эх үүсвэрт ашиглах боломжит нөөцийн судалгаа хийнэ.	БОНХЯ	УУЯ, ЭЗХЯ, СЯ, СГЗ	2014-2021	Хувийн болон бусад
3.7	Шинээр ашиглалтад орох уул уурхайн ус хангамжийн асуудлыг шийдвэрлэх	Оюу Толгой, Донод, Гурванбулаг, Хараат, Хайрхан, Дулаан-Уул, Зөвч-Уул, Асгат, Цагаан суварга, Таван толгой, Нарийн Сүхэйт, Бороо, Олон овоот, Төмөртэйн овоо, Чойр-Нялга, Бүрэнхаан зэрэг ашигт малтмалын орд газруудад ус хангамжийн барилга байгууламжийг барьж байгуулна. "Орхон-Говь" төслийн ТЭЗҮ-ийг боловсруулж, экологид халгүй эдийн засгийн ашигтай нь тогтоогдвол хэрэгжүүлнэ.	УУЯ	СЯ, аймаг, нийслэлийн ИТХ, СГЗ	2014-2021	Хувийн болон бусад
3.8	Уул уурхайн усыг дахин ашиглах	Оюу Толгой, Асгат, Цагаан суварга, Таван толгой, Нарийн Сүхэйт, Бороо, Шивээ овоо, Олон овоот, Мардай, Гурванбулаг, Бүрэнхаан, Шивээ овоо, Дулаан-Уул, Хараат зэрэг ашигт малтмалын орд газруудад үйлдвэрлэлд ашигласан усыг эргүүлэн ашиглах технологи нэвтрүүлнэ.	УУЯ, СГЗ	-	2014-2021	Хувийн болон бусад
	Усан цахилгаан станц барих газрын хайгуул	Баян-Өлгий, Ховд аймгууд дахь томоохон голууд болон Сэлэнгэ,	УУЯ, МХЕГ, ОБЕГ	СГЗ	2014-2021	-Улсын төсөв -Хувийн болон бусад



№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Үйл ажиллагаа	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэгч	Хугацаа	Санхүүжилтийн эх үүсвэр
3.9	судалгаа хийж, ТЭЗУ, зураг төсөл боловсруулах	Орхон зэрэг томоохон голуудын дагууд хайгуул судалгаа хийж, УЦС-ын боомт барих боломжийг судална.				бусад
3.10	Усан цахилгаан станц шинээр байгуулах, сэргээн засварлах	Сэлэнгэ мөрөн дээр усан цахилгаан станц барих ТЭЗУ боловсруулна.	ЭХЯ	БОАЖЯ, ЭЗХЯ, СЯ, СГЗ	2014-2021	Хувийн болон бусад
3.11	Усан цахилгаан станцын усны горимд байнгын хяналт тавих	Усан цахилгаан станцуудын усан сангийн үйл ажиллагаанаас голын усны горимд нөлөөлөх нөлөөлд хяналт тавина.	СГЗ	БОНХЯ, СЯ	2014-2021	Улсын төсөв
3.12	Одоо байгаа болон шинээр байгуулагдах дулааны цахилгаан станцын ус хангамжийн асуудлыг шийдвэрлэх	Шинээр байгуулагдах ДЦС-уудын усны эх үүсвэрийн хайгуул, судалгаа хийж шинэ эх үүсвэрүүд байгуулна. Одоо байгаа ДЦС-уудын усны алдагдлыг бууруулан ус дахин ашиглалтыг нэмэгдүүлнэ.	ЭХЯ	СЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ, СГЗ	2014-2021	Улсын төсөв
3.13	Газрын гүний халуун усыг ашиглах боломжийг судлах	Хангайн бүсэд газрын гүний халуун усыг ашиглах судалгаа хийж, тогтоогдсон газруудад гүний халуун усыг ашиглана.	ЭХЯ	Аймаг, нийслэлийн ЗДТГ, СГЗ	2014-2021	-Улсын төсөв -Гадаадын зээл тусламж
4.1	Гол мөрний урсац бүрэлдэх эхийн хамгаалалтын бүсийн дэглэмийг тогтоож, мөрдүүлэх	4. Хүрээлэн буй орчны тэнцвэрт байдлыг хангах, усны нөөцийг хамгаалах үндсэн зорилтын хүрээнд: Монгол орны гадаргын усны нөөцийн 70 хувь бүрдэх сав газрын эхэд хамаарах хэсгийг улсын болон орон нутгийн хамгаалалтад авч, ой, ургамлан нөмрөгийг нөхөн сэргээх ажлыг хийнэ. (Сэлэнгэ, Орхон, Хэрлэн, Туул, Хараа, Онон, Ховд, Буянт, Завхан, Цэнхэр, Идэр, Чулуут, Дэлгэрмөрөн, Тамир, Түй, Таац, Онги, Байдраг, Шишхэд,	БОНХЯ, СГЗ	СЯ, МХЕГ, ОБЕГ, аймаг, нийслэлийн ЗДТГ	2014-2021	Улсын төсөв

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Үйл ажиллагаа	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэгч	Хугацаа	Санхүүжилтийн эх үүсвэр
4.2	Усны сан бүхий газруудын онцгой болон энгийн хамгаалалтын бүсийг тогтоож, мөрдүүлэх	Булган, Сэлбэ, Ерөө, Тэс голууд) Усны сан бүхий газруудын хамгаалалтын бүсийг тогтоож, тэмдэгжүүлнэ.	БОНХЯ, СГЗ	СЯ, МХЕГ, ОБЕГ, аймаг, нийслэлийн ЗДТГ	2014-2021	Улсын төсөв
4.3	Усны нөөц бүрэлдэн бий болох, хувьсан өөрчлөгдөх зүй тогтлыг үндэслэн усны нөөц, ашиглах боломжит нөөцийн хэмжээг тогтоох эрэл хайгуулын ажлыг хийж, ашиглалтыг тогтоосон хэмжээнд нь мөрдүүлэх	Монгол орны ашиглах боломжит усны нөөцийн зургийг шинэчилэн боловсруулж усны нөөцийн цаашдын чиг хандлагыг тодорхойлно.	БОНХЯ, СГЗ	СЯ, МХЕГ, ОБЕГ	2014-2021	Улсын төсөв
4.4	Ус хэрэглэгч, ашиглагчдыг тоолууржуулах	Орон сууцны хэрэглэгчид болон, үйлдвэрийн усны алдагдлыг бууруулан улмаар ус хэрэглээ-ашиглалтыг зохих түвшинд хүртэл багасгаж, тоолууржуулах ажлыг эрчимжүүлнэ.	БХБЯ, ҮХААЯ	БОНХЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ, СГЗ	2014-2021	Хувийн болон бусад
4.5	Хот, суурины эзэмшил газарт хамаарах голын эргийг тохижуулах	Хот суурин газрын суурьшлын бүс дэх голын эргийн дагуух орчны бохирдлыг бууруулах ажлыг зохион байгуулна.	БХБЯ	Аймаг, нийслэлийн ЗДТГ	2014-2021	-Улсын төсөв -Орон нутгийн төсөв
4.6	Урсац тохируулах, ус хуримтлуулах усан сан байгуулах	Боомт, усан сан байгуулах боломжит газруудад хайгуул, судалгаа хийж, ТЭЗУ болон зураг төсөл боловсруулна.	БОНХЯ, БХБЯ	Аймаг, нийслэлийн ИТХ, ЗДТГ	2014-2021	-Улсын төсөв -Гадаадын зээл тусламж
4.7	Усны нөөцийг бохирдлоос хамгаалах	Бохирдуулагч эх үүсвэрүүдийг тооллого судалгаа хийнэ.	БОНХЯ	СЯ, МХЕГ, ОБЕГ, аймаг, нийслэлийн ЗДТГ, СГЗ	2014-2021	-Улсын төсөв -Орон нутгийн төсөв



№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Үйл ажиллагаа	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэгч	Хугацаа	Санхүүжилтийн эх үүсвэр
4.8	Бохирдуулагч төлөх зарчмыг хэрэгжүүлэх	Ус бохирдуулсны төлбөрийн орлогын нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.	БОНХЯ	СЯ, МХЕГ, ОБЕГ, аймаг, нийслэлийн ЗДТГ, СГЗ	2014-2021	-Улсын төсөв -Орон нутгийн төсөв
4.9	Гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг сайжруулах	Хот, суурины газруудын гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг сайжруулна.	БОНХЯ, БХБЯ	Аймаг, нийслэлийн ЗДТГ	2014-2021	-Улсын төсөв -Гадаадын зээл тусламж -Хувийн болон бусад
4.10	Томоохон голуудын экологийн урсцыг тодорхойлох судалгаа хийх	Монгол орны томоохон голууд болох Сэлэнгэ, Орхон, Хэрлэн, Түүл, Хараа, Онон, Ховд, Буянт, Завхан, Цэнхэр, Идэр, Чулуут, Дэлгэрмөрөн, Тамир, Түй, Таац, Онги, Байдраг, Сэлбэ, Ерөө, Тэс голуудын экологийн урсцыг тодорхойлох судалгаа хийнэ.	БОНХЯ	СЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ, СГЗ	2014-2021	-Улсын төсөв -Гадаадын зээл тусламж
4.11	Рамсарын Конвенцийн хэрэгжилтийг хангах, гэрээнд хамрагдах ус, намгархаг газрын тоог нэмэгдүүлэх	Ус, намгархаг газрыг хамгаалалтад авах ажлыг зохион байгуулна.	БОНХЯ	СЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ, СГЗ	2014-2021	-
4.12	Экосистемийн тэнцвэрт байдлыг хангах, биологийн төрөл зүйлийг хамгаалах, усыг байгальд хадгалах (үлдээх) нөхцлийг бүрдүүлэх	Гадаргын болон газрын доорхи усны нөөцийг бохирдол, хомсдлоос хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлнэ.	БОНХЯ	СЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ, СГЗ	2014-2021	Улсын төсөв
4.13	Хот суурин газрын ногоон байгууламжийн усалгааны арга технологийг шинэчлэлт хийж, усалгааны горимыг	Улаанбаатар болон бусад томоохон хотуудад ногоон байгууламжийн усалгаанд орчин үеийн дэвшилтэт технологи	БОНХЯ	Аймаг, нийслэлийн ЗДТГ, СГЗ	2014-2021	Улсын төсөв



№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Үйл ажиллагаа	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэгч	Хугацаа	Санхүүжилтийн эх үүсвэр
	мөрдүүлэх	нэвтрүүлнэ.				
4.14	Хүний бурхутай үйл ажиллагааны улмаас газрын доорх усны түвшин буурахаас урьдчилан сэргийлэх	Газрын доорх усны хяналт-шинжилгээний сүлжээг өргөжүүлж, уст цэгийн орчмын ногоон байгууламжийг сайжруулна.	БОНХЯ	БХБЯ, УХААЯ, ССАЖЯ, УУЯ, МХЕГ, ОБЕГ, аймаг, нийслэлийн ЗДТГ, СГЗ	2014-2021	Улсын төсөв
4.15	Байгалийн горим эвдэгдсэн, бохирдсон голуудын голдрилд үзлэг хийж, нөхөн сэргээх	Голын голдрил, татам, хөндийн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалан, байгалийн горим алдагдсан газруудад нөхөн сэргээлт хийж, усны нөөцийг хамгаална.	БОНХЯ, СГЗ	УХААЯ, УУЯ, СЯ, МХЕГ, ОБЕГ, аймаг, нийслэлийн ЗДТГ	2014-2021	-Улсын төсөв -Хувийн болон бусад
4.16	Экологийн өөрчлөлтөнд орж буй гол, нууруудыг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авч, нөхөн сэргээх арга хэмжээ авах	Орхон, Туулын болон бусад голын сав газар дахь ой, ус, намгархаг газруудыг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авч, нөхөн сэргээх арга хэмжээ авна.	БОНХЯ, СГЗ	УХААЯ, УУЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ	2014-2021	-Улсын төсөв -Орон нутгийн төсөв -Гадаадын зээл тусламж
4.17	Үерийн хамгаалалтын Байгууламжийг засварлах, шинээр байгуулах	Улаанбаатар хотын томоохон үерийн далангууд болон Туул, Улиастай, Сэлбэ голуудын үерийн хамгаалалтын далан сувгийг сэргээн засварлах, шинээр барьж байгуулах ажлыг зохион байгуулна.	БХБЯ	СЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ	2014-2021	Улсын төсөв
4.18	Хот, суурин газрын зам, талбайн борооны ус	Аймгийн төвүүд, томоохон хот суурин газруудын үерийн хамгаалалтын далан, сувгийг сэргээн засварлана. Улаанбаатар болон бусад томоохон хотуудын зам, талбайн	ЗТЯ	СЯ, аймаг, нийслэлийн	2014-2021	Улсын төсөв



№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Үйл ажиллагаа	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэгч	Хугацаа	Санхүүжилтийн эх үүсвэр
	Зайлуулах байгууламжийн асуудлыг шийдвэрлэх	Уерийн хамгаалалтын болон зам талбайн борооны ус зайлуулах барилга байгууламжийн эзэмшил, ашиглалтын менежментийг оновчтой шийдвэрлэх	ЗТЯ	Аймаг, нийслэлийн ИТХ, ЗДТГ, СГЗ	2014-2021	-
4.19	Ган, цөлжилт, хуурайшилтын онцгой нөхцөлд хэрэгжүүлэх усны менежментийн аргачилсан заавар боловсруулж, мөрдүүлэх	Ган, цөлжилт, хуурайшилтын онцгой нөхцөлд хэрэгжүүлэх усны менежментийн аргачлал боловсруулж, мөрдүүлэх ажлыг зохион байгуулна.	ОБЕГ, СГЗ	БОНХЯ, УХААЯ, СЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ	2014-2021	-
4.21	Унах хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор газрын генератор суурилуулах	Унах хур тунадасны нэмэгдүүлэх зорилгоор 35 хүртэлх тооны газрын генераторыг суурилуулан ажиллуулна.	БОНХЯ	СЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ	2014-2021	Улсын төсөв
5. Усны оновчтой менежментийг хэрэгжүүлэх, салбар дундын зохицуулалтыг хангах үндсэн зорилтын хүрээнд:						
	Устай холбоотой хуулиудыг уялдуулан, "Усны харилцааны багц хууль"-ийн үзэл баримтлалаар шинэчлэх	Устай холбоотой хууль, толгоомж, дүрэм, журам, заавар, норматив, стандартуудын давхардал, хийдэл, түүнээс улбаалан хэрэгжилтийн үр нөлөө буурдаг явдлыг арилгаж, нэр томъёоллыг нэг мөр болгоно. Олон улсын гэрээ, хэлэлцээр, хилийн усны хэлэлцээрийн билэлтийг сайжруулна.	БОНХЯ,	СЯ, ХЗЯ	2014-2021	-
5.2	Дүрэм, журам, норм	Монгол улсад мөрдөгдөж байгаа	БОНХЯ	СЯ, аймаг,	2014-2021	-

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Үйл ажиллагаа	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэгч нийслэлийн ЗДТГ, СГЗ	Хугацаа	Санхүүжилтийн эх үүсвэр
	норматив, стандартыг шинэчлэн сайжруулах	устай холбоотой дүрэм, журам, норм норматив, стандартуудыг хэрэгжилтэд үнэлгээ өгч шаардлагатай тохиолдолд шинэчлэн боловсруулна.		нийслэлийн ЗДТГ, СГЗ		
5.3	Усны салбарын гадаад харилцаа, хилийн усны гэрээ хэлэлцээрийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох	ОХУ болон БНХАУ-тай байгуулсан хилийн усны хэлэлцээрийн хэрэгжилтийг ханган ажиллана.	БОНХЯ	Аймаг, нийслэлийн ЗДТГ, СГЗ	2014-2021	-
5.4	Мөрдөгдөж буй хууль, тогтоомж, дүрэм, журмын хэрэгжих нөхцлийг сайжруулах	Олон нийтэд хууль эрхзүйн мэдлэг, мэдээлэл олгох сургалт, сурталчилгааг эрчимжүүлнэ.	БОНХЯ	МХЕГ, аймаг, нийслэлийн ЗДТГ, СГЗ	2014-2021	-
5.5	Усны асуудал эрхэлсэн Засгийн газрын эрх бүхий байгууллагын статус, эрх, үүргийг шинэчлэх	Усны нөөцийн нэгдсэн менежментийн зарчмыг нэвтрүүлэн, сав газрын байгууллагуудын үйл ажиллагааг бэхжүүлж, усны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн болон хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын чадавхийг нэмэгдүүлнэ.		БОНХЯ, СЯ, ХЗЯ	2014-2021	-
5.6	Салбар дундын зохицуулалтын механизмыг боловсронгуй болгох	Усны салбарын байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулна.		БОНХЯ, СЯ	2014-2021	-
5.7	Улс, орон нутгийн түвшинд усны асуудал эрхэлсэн байгууллагуудын үйл ажиллагаа, уялдааг сайжруулах	Улс, орон нутгийн түвшинд усны асуудал эрхэлсэн Сав газрын байгууллагуудын үүрэг, хариуцлагыг оновчтой тодорхойлно.	СГЗ	БОНХЯ, СЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ	2014-2021	-
5.8	Усны мэргэжлийн болон	Боловсон хүчний чадавхийг	БШУЯ	БОНХЯ, СЯ,	2014-2021	-



№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Үйл ажиллагаа	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэгч	Хугацаа	Санхүүжилтийн эх үүсвэр
5.9	эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагууд, төрийн бус байгууллагуудыг бэхжүүлж, усны менежментэд тэдгээрийн оролцоог нэмэгдүүлэх Усны салбарын мэдээллийн солилцоо, хяналт, хамгаалалт, хүртээмжийг бүх шатанд сайжруулах	дээшлүүлэх, төсвийг нь нэмэгдүүлэх, тоног төхөөрөмжийг нь сайжруулах замаар усны менежментэд оролцогч эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагууд, төрийн бус байгууллагуудыг бэхжүүлнэ. Мэдээлэл цуглуулах, боловсруулах, хадгалах, чанарыг дээшлүүлэх чиглэлээр төсөв хөрөнгө нэмэгдүүлж, байгууллага хоорондын мэдээлэл солилцоо, хяналтыг сайжруулна.	СГЗ	БОНХЯ, СЯ	2014-2021	-
5.10	Сав газрын байгууллагуудыг бэхжүүлэх, тэдгээрийн үйл ажиллагааг тогтмолжуулан, усны менежментэд гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх тодорхой төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх	Сав газрын байгууллагуудын үйл ажиллагааг бэхжүүлэх, хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх зорилгоор усны нөөцийн нэгдсэн менежментийн сургалтын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.	БОНХЯ, СГЗ	СЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ	2014-2021	-
5.11	Усны үнийн бодлогыг шинэчилж, өртгөө нөхөх түвшинг дээшлүүлэх	Усны үнийн бодлогыг шинэчлэн боловсруулж, үнийг бодит өртөг зардалд нь тохируулан тогтоох ажлыг зохион байгуулна. Өртгөө нөхөх түвшинг тодорхой болгоно.	БОНХЯ, БХБЯ, УХААЯ	СЯ, СГЗ	2014-2021	Улсын төсөв
5.12	Усны салбарын төлөвлөсөн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор санхүүжилтийн нэмэлт эх үүсвэр болон	Төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих замаар хувийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.	БОНХЯ, БХБЯ, УХААЯ	СЯ, СГЗ	2014-2021	Улсын төсөв

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Үйл ажиллагаа	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэгч	Хугацаа	Санхүүжилтийн эх үүсвэр
	Хэрэгжүүлэх арга хэмжээ боловсруулах					
5.13	Усны салбарын үр ашгийг нэмэгдүүлж, зардлыг бууруулах	Усны салбарын төлөвлөлт, удирдлага, үйл ажиллагаанд оролцогч байгууллагуудын уялдаа холбоог сайжруулна.	БОНХЯ, БХБЯ, УХААЯ	СЯ, СГЗ	2014-2021	Улсын төсөв
5.14	Усны салбарын хүний нөөцийн чадавхийг сайжруулах	Салбарын хөдөлмөрийн нөхцлийг хувийн салбартай өрсөлдөхүйц түвшинд хүргэх, салбарын хүний нөөцийн хэрэгцээнд тулгуурлан сургалтын төвүүд ажиллуулах, залуучуудыг үйлдвэрлэлд дагалдан суралцуулах ажлыг зохион байгуулна.	СГЗ	БОНХЯ, БШУЯ, СЯ	2014-2021	-
5.15	Усны салбарын мэргэжлийн боловсон хүчний чадавхийг бүх шатанд нэмэгдүүлэх боломжийг судлах	Усны менежмент, инженер болон техникийн ажилтнууд бэлтгэх тусгай заавар боловсруулна.		БОНХЯ, БШУЯ, СЯ, СГЗ	2014-2021	Улсын төсөв
5.16	Усны салбарын боловсон хүчнийг бэлдэх бүх шатны байгууллагуудад сургалтын чанар дээшлүүлэх талаар судалгаа хийж, зөвлөмж боловсруулах	Их, дээд сургуулиуд, техник мэргэжлийн сургуулиудын сургалтын хөтөлбөрт өөрчлөлт хийж зөвлөмж гаргана.		БОНХЯ, БШУЯ, СЯ, СГЗ	2014-2021	Улсын төсөв
5.17	Усны нөөц, чанарын мониторингийн сүлжээг бий болгох, өргөтгөх, шинэчлэх	Мониторингийн орчин үеийн шинэлэг техник, технолог, арга, аргачлал нэвтрүүлэх замаар мониторингийн мэдээллийг сайжруулна. Томоохон голуудын дагууд болон шаардлагатай байрлалд газрын доорхи усны	БОНХЯ	СЯ, СГЗ	2014-2021	Улсын төсөв



№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Үйл ажиллагаа	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэгч	Хугацаа	Санхүүжилтийн эх үүсвэр
		мониторингийн цэгүүд шинээр байгуулж, мониторингийн сүлжээг өргөжүүлнэ. Газрын доорхи усны судалгаа хариуцсан эрдэм шинжилгээний төвтэй болно				
5.18	Усны шинжилгээний лабораторийн багаж, тоног төхөөрөмжийг шинэчлэх, шинжилгээний түвшинг дээшлүүлэх	Хүнд металл, органик бус бодис зэрэг зайшгүй шаардлагатай химийн элементүүд, параметруудийг тодорхойлох боломж бүхий лабораторийн сүүлийн үеийн багаж, тоног төхөөрөмж нэвтрүүлнэ.	БОНХЯ, МХЕГ	СЯ, СГЗ	2014-2021	Улсын төсөв
5.19	Мониторингийн хөтөлбөрийг боловсронгуй болгож, хэрэгжүүлэх	Мониторингийн мэдээллийн ашигт чанар, хамралт, хүртээмжийн шинжилгээ хийнэ.	БОНХЯ	СЯ, СГЗ	2014-2021	-
5.20	Усны салбарын эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг өргөжүүлэх	Гадаргын болон газрын доорхи усны чанарын хяналт-шинжилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын уялдаа холбоог сайжруулна.	БОНХЯ	БШУЯ, СЯ, СГЗ	2014-2021	-
5.21	Мэдээллийн санг бэхжүүлж, мэдээлэл солилцоог сайжруулах	2015 он хүртэл усны салбарын бүх байгууллагууд мэдээллээ оруулах, хадгалах, ашиглах, түүнчлэн сонирхсон талууд ашиглах боломжтой мэдээллийн нэгдсэн сан байгуулж, цаашид сайжруулна.	БОНХЯ	ЗГ-ын бүх яамд, МХЕГ, ОБЕГ, СГЗ	2014-2021	Улсын төсөв
5.22	Сав газрын түвшинд мэдээллийн сан бий болгох	Усны нэгдсэн мэдээллийн сантай шууд холбоотой сав газруудын мэдээллийн санг бүрдүүлнэ.	БОНХЯ, СГЗ	СЯ, аймаг, нийслэлийн ИТХ, ЗДТГ	2014-2021	Улсын төсөв
5.23	Үр дүнг мэдээлэх тогтмол	Бүх шатны Сав газрын	БОНХЯ, СГЗ	СЯ	2014-2021	-

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Үйл ажиллагаа	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэгч	Хугацаа	Санхүүжилтийн эх үүсвэр
	Хэрэгжүүлэх арга хэмжээ хэвлэлтэй болох	байгууллагууд жил бүр тайлан гаргаж, ажлын үр дүнг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаар тогтмол мэдээнэ.				
5.24	Салбарын мэргэшсэн мэргэжилтнүүдийн оролцоотойгоор тодорхой зорилтот бүлгүүдэд цогц мэдээлэл, сурталчилгаа хийх, тэдний мэдлэгийг дээшлүүлэх стратеги боловсруулах	Олон нийтийн сэтгэл зүй, харилцаа болон нийтийн мэдээллийн талаар мэргэшсэн байгууллагатай хамтран иргэдийн усны боловсролыг дээшлүүлэх, мэдээлэл, сурталчилгаа, итгэл үнэмшлийг нэмэгдүүлэх нарийвчилсан төлөвлөгөө боловсруулна.	СГЗ	СЯ	2014-2021	Улсын төсөв
5.25	Олон нийтэд мэдээлэл, сурталчилгаа хийхээр боловсруулсан стратегийг хэрэгжүүлэх	Олон нийтийн харилцаа, мэдээлэл, сурталчилгааны хөтөлбөрт ТББ-уудыг татан оролцуулна.	СГЗ	СЯ	2014-2021	-
5.26	Усны нөөцийн хэмжээ, чанар, түүний ашиглалттай холбоотой мэдээ, мэдээллийг олон нийтэд нээлттэй хүргэх	Цахим мэдээлэл авах боломжийг бүрдүүлж, жил бүрийн тайланг хэвлэж, нийтийн хүртээл болгоно.	БОНХЯ, БХБЯ, СГЗ	УХААЯ, УУЯ, ЭХЯ	2014-2021	-
5.27	Усны нөөцийг хамгаалах ардын уламжлалт зан үйлийг сэргээн сурталчилах	Усны нөөцийг бохирдлоос хамгаалах ажлыг усаа хамгаалах уламжлалт ёс заншилтай хамтруулан хэрэгжүүлнэ.	БОНХЯ, СГЗ	СЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ	2014-2021	
5.28	Усны менежментийн бүх шатанд олон нийтийн төлөөлөл болгон ТББ-ын оролцоог нэмэгдүүлэх	Устай холбоотой аливаа төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхэд төрийн бус байгууллага, олон нийтийн оролцоог хангаж, хамтран ажиллана.	БОНХЯ, СГЗ	СЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ	2014-2021	Улсын төсөв



Товчилсон үгийн тайлбар:

БОНХЯ	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам
СЯ	Сангийн яам
БХБЯ	Барилга хот байгуулалтын яам
ҮХААЯ	Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам
ЭЗХЯ	Эдийн засгийн хөгжлийн яам
УУЯ	Уул уурхайн яам
ЭХЯ	Эрчим хүчний яам
ЗТЯ	Зам тээврийн яам
ХЗЯ	Хууль зүйн яам
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
БХЯ	Батлан хамгаалах яам
ССАЖЯ	Соёл, спорт, аялал жуулчлалын яам
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
СГЗ	Сав газрын захиргаа

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn
Утас: 262420
Хэвлэлийн хуудас: 3
Индекс: 14003